



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн баталж мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан 2005 оны 2 дугаар улиралд багтаан батлуулахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /С.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2004 оны “Дүрэм батлах тухай” 378 дугаар захирамжийн хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
4 сарын 25 ны өдрийн
161 дүрэм захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газар /цаашид "газар" гэх/ нь нийслэлийн нутаг дэвсгэрт гарч болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, гамшгийн үед нэрвэгдэгсдийг аврах, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үүрэг бүхий төрийн тусгай албаны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын, Гамшгаас хамгаалах, Галын аюулгүй байдлын, Ой, хээрийг түймрээс хамгаалах, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн, Төрийн албаны, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, ерөнхий газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын шийдвэр, мөрийн хөтөлбөр, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль тогтоомжууд, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.3. Газар нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, төрийн захиргааны байгууллагаас мэргэжил, арга зүйн удирдлагаар хангагдаж, нийслэлийн Засаг даргын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.5. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга тогтоож, газрын даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсний үндсэн дээр Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар томилж, чөлөөлнө.

1.6. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч дарга, хэлтсийн дарга нарыг томилж, чөлөөлүүлэх саналаа Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

1.7. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан офицер, ахлагчдыг томилуулах саналаа Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулж, ажилтан, албан хаагчдыг өөрийн тушаалаар томилж, чөлөөлнө.

1.8. Газрын дарга нь бүрэн эрх хэмжээний асуудлаар хууль, тогтоомжинд нийцүүлэн тушаал гаргана.

1.9. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих

2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтмол тайлагнаж ажиллах.

2.3. Дүүрэг,албад, аж ахуйн нэгж байгууллагад гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлж, арга зүйн удирдлагаар хангах

2.4. Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр төрийн болон нутгийн захиргаа, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, харьяа салбар нэгждээ гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, захиран зарцуулах, нөхөн сэлбэх үйл ажиллагаанд хяналт тавих;

2.5. Гамшгаас хамгаалах бүх ангиллын сургалтыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах,явц байдалд хяналт тавих

2.6. Дүүрэг,албад нэгж байгууллагын нутаг дэвсгэрийн онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах алба, штаб, мэргэжлийн ангиудыг байгуулж, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох

2.7. Дүүрэг,албад,аж ахуйн нэгж, байгууллагын гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх

2.8. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх,аврах хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг дэс дараатай явуулах зорилгоор нийслэл хотыг гамшгаас хамгаалахын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналыг нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх

2.9 Гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ,хор уршгийг арилгах талаар төрийн ба төрийн бус ,нутгийн захиргааны болон хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажиллах

2.10. Гамшгаас хамгаалах талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

2.11. Гамшгаас хамгаалах асуудлаар гадаад орны болон олон улсын холбогдох байгууллагуудтай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх

2.12. Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн дагуу гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд шаардагдах хүн хүч, техник, материал хэрэгслийг орон нутгаас дайчлан гаргаж ажиллуулах

2.13. Гамшгийн аюулын тухай мэдээ, зарлан мэдээллийн дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг дамжуулах үүрэг бүхий харилцаа, холбооны байгууллагын техник хэрэгслийг өдөр тутмын бэлэн байдалд байлгах

2.14. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд нийтээр дагаж мөрдөх заавар, журам, норм, нормативийн хэрэгжилтийг хангахад хяналт тавих

2.15. Гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлэх, тэднээс мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга, туслалцаа авах;

2.16. Гамшгаас хамгаалах хяналтын үйл ажиллагааг нийслэлийн хяналтын бусад албадтай уялдуулан зохион байгуулж ажиллах

2.17. Төрийн тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчдыг өдөр тутам албан үүргээ гүйцэтгэхдээ ажил, мэргэжлийн онцлогт тохирсон цол ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцас хэрэглүүлэх, сахилгын дүрмээр хүлээсэн үүргээ чанг сахин мөрдүүлэхэд нь хяналт тавих

2.18. Гамшгаас хамгаалах талаархи бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, гамшгийн цагийн байдал, авсан арга хэмжээний талаархи мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэгийг нийслэлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах

2.19. Гамшгаас хамгаалах байгууллагын боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллах

2.20. Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах

2.21. Газрын даргын нийтлэг хэм хэмжээг тогтоосон шийдвэрийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах

Гурав. Газрын эрх

3.1. Батлагдсан төсөв, байгууллага, ард иргэдээс ирсэн хандив тусламжийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах, барилга байгууламж, машин техник, тоног төхөөрөмжийг засварлан сэлбэх, шинээр барьж байгуулах, эдэлгээ ашиглалтыг нь сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, буруутай үйл ажиллагаанд нь зохих хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан шийдвэрт заасны дагуу хариуцлага хүлээлгэх.

3.3. Гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагчид нь батлагдсан үнэмлэх, тэмдэг, албан шаардлага, акт, торгууль, шийтгэврийн хуудас хэрэглэх

3.4. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар асуудал боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх.

3.5. Ажлын зайлшгүй шаардлагаар баримт бичиг, тодорхойлолт, магадлагаа, тайлан илтгэл, тооцоо судалгааг тогтоосон журмын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах

3.6. Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, төлөөлөх:

3.7. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.8. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, холбогдох байгууллагад тавих

3.9. Гамшгаас хамгаалах талаар гаргасан эмхтгэл, гарын авлага, зөвлөмжийг хэвлэн нийтлүүлэх.

3.10. Гамшгаас хамгаалах талаар төсөл хэрэгжүүлэх ажилд оролцох

3.11. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэнэ

3.12. Байгууллагын үйл ажиллагаа, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах

Дөрөв. Хариуцлага

4.1. Газрын дарга, орлогч, ажилтанууд нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэм, дотоод журамд заасан ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

4.2. Хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн сахилгын дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

Тав. Бусад

1. Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулах ба өөрчлөлт нь дүрмийн салшгүй хэсэг болно.

-----oOo-----